



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/393

Булган сум

Архи, согтууруулах ундаа худалдах, үйлчлэх,
хэрэглэхийг хориглох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Хүүхдийн эрхийг хамгаалах, гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэрэг, зөрчил, аюул ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр-хүүхдийн баяр”-ыг аймгийн хэмжээнд архи, согтууруулах ундаа хэрэглэхгүй өдөр болгон тэмдэглэсүгэй.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр-хүүхдийн баяр” 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдөр архи, согтууруулах ундаа худалдах, үйлчлэх, хэрэглэхийг хориглосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Цагдаагийн дэд хурандаа Г.Ганбаяр) –т даалгасугай.

4. Захирамжийг хэрэгжүүлэн ажиллахыг архи, согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, бүх сумын Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ